



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 3 дугаар
сарын 11-ний өдөр

Дугаар 94

Улаанбаатар
хот

Алт олборлолтыг нэмэгдүүлж, эдийн
засгийг эрчимжүүлэх зарим арга
хэмжээний тухай

Улсын Их Хурлын 2015 оны 41 дүгээр тогтоолоор баталсан "Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр"-ийн 7.1, 7.2, 10.1 дэх зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Ашигт малтмалын тухай хуулийн 9.1.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Эдийн засгийн өсөлтийг хангаж, улсын валютын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор олборлоход бэлэн болсон алтны ордын хөрөнгө оруулалтад шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг судалж шийдвэрлэхийг Сангийн сайд Ж.Эрдэнэбат, Уул уурхайн сайд Р.Жигжид нарт даалгаж, санхүүжилтийн оновчтой схемийг боловсруулахад дэмжлэг үзүүлж ажиллахыг Монголбанкны ерөнхийлөгч Н.Золжаргалд зөвлөсүгэй.

2. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжтой болж, гэрээ байгуулсан аж ахуйн нэгжид шаардлагатай санхүүгийн эх үүсвэр олгуулах асуудлыг судалж шийдвэрлэхийг Сангийн сайд Ж.Эрдэнэбат, Уул уурхайн сайд Р.Жигжид нарт даалгаж, санхүүжилтийн оновчтой хувилбар боловсруулахад дэмжлэг үзүүлэхийг Монголбанкны ерөнхийлөгч Н.Золжаргалд зөвлөсүгэй.

3. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Уул уурхайн сайд Р.Жигжид нарт даалгасугай:

3.1. гол, мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээлт хийлгэх журам болон гэрээний загварыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, 2015 оны 4 дүгээр сарын 1-ний дотор Засгийн газрын хуралдаанд оруулж батлуулах;

3.2. усны сан бүхий газрын энгийн болон онцгой хамгаалалттай бүсийн хилийн заагийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шуурхай тогтоох;

3.3. ашигт малтмалын нөөцийн тодотгол, техник, эдийн засгийн үндэслэл болон байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланг бүртгэх, хүлээн авах ажлыг шуурхай зохион байгуулах;

119

3.4. "Геологи, уул уурхайн салбарыг хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2002 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 103 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх замаар байгаль орчинд ээлтэй технологи нэвтрүүлэн ажиллаж байгаа шороон ордыг ашиглах боломжийг судалж шийдвэрлэх.

4. Улсын хилийн зурвас болон тусгай хэрэгцээний газар дахь хууль бус олборлолтод өртсөн алтны орд, илрэлүүдийг хамгаалалтад авч, шаардлагатай зарим ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах асуудлыг судалж, саналаа холбогдох шийдвэрийн төслийн хамт 2015 оны II улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Уул уурхайн сайд Р.Жигжид, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Хууль зүйн сайд Д.Дорлигжав, Батлан хамгаалахын сайд Ц.Цолмон нарт даалгасугай.

5. Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвийн Сорьцын хяналтын албыг бэхжүүлж, бүртгэлийн системийг боловсронгуй болгох талаар санал боловсруулж 2015 оны 4 дүгээр сарын 1-ний дотор Засгийн газарт танилцуулахыг Монгол Улсын Шадар сайд У.Хүрэлсүх, Сангийн сайд Ж.Эрдэнэбат, Уул уурхайн сайд Р.Жигжид нарт даалгасугай.


6. Энэ тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулахад шаардлагатай дэмжлэг үзүүлж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогт, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгож, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд зөвлөсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд

Ч.САЙХАНБИЛЭГ

Уул уурхайн сайд

Р.ЖИГЖИД



3.4. "Геологи, уул уурхайн салбарыг хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2002 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 103 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх замаар байгаль орчинд ээлтэй технологи нэвтрүүлэн ажиллаж байгаа шороон ордыг ашиглах боломжийг судалж шийдвэрлэх.

4. Улсын хилийн зурвас болон тусгай хэрэгцээний газар дахь хууль бус олборлолтод өртсөн алтны орд, илрэлүүдийг хамгаалалтад авч, шаардлагатай зарим ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах асуудлыг судалж, саналаа холбогдох шийдвэрийн төслийн хамт 2015 оны II улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Уул уурхайн сайд Р.Жигжид, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Хууль зүйн сайд Д.Дорлигжав, Батлан хамгаалахын сайд Ц.Цолмон нарт даалгасугай.

5. Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвийн Сорьцын хяналтын албыг бэхжүүлж, бүртгэлийн системийг боловсронгуй болгох талаар санал боловсруулж 2015 оны 4 дүгээр сарын 1-ний дотор Засгийн газарт танилцуулахыг Монгол Улсын Шадар сайд У.Хүрэлсүх, Сангийн сайд Ж.Эрдэнэбат, Уул уурхайн сайд Р.Жигжид нарт даалгасугай.


6. Энэ тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулахад шаардлагатай дэмжлэг үзүүлж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогт, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгож, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд зөвлөсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд

Ч.САЙХАНБИЛЭГ

Уул уурхайн сайд

Р.ЖИГЖИД





МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 3 дугаар
сарын 11-ний өдөр

Дугаар 94

Улаанбаатар
хот

Алт олборлолтыг нэмэгдүүлж, эдийн
засгийг эрчимжүүлэх зарим арга
хэмжээний тухай

Улсын Их Хурлын 2015 оны 41 дүгээр тогтоолоор баталсан "Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр"-ийн 7.1, 7.2, 10.1 дэх зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Ашигт малтмалын тухай хуулийн 9.1.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Эдийн засгийн өсөлтийг хангаж, улсын валютын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор олборлоход бэлэн болсон алтны ордын хөрөнгө оруулалтад шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг судалж шийдвэрлэхийг Сангийн сайд Ж.Эрдэнэбат, Уул уурхайн сайд Р.Жигжид нарт даалгаж, санхүүжилтийн оновчтой схемийг боловсруулахад дэмжлэг үзүүлж ажиллахыг Монголбанкны ерөнхийлөгч Н.Золжаргалд зөвлөсүгэй.

2. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжтой болж, гэрээ байгуулсан аж ахуйн нэгжид шаардлагатай санхүүгийн эх үүсвэр олгуулах асуудлыг судалж шийдвэрлэхийг Сангийн сайд Ж.Эрдэнэбат, Уул уурхайн сайд Р.Жигжид нарт даалгаж, санхүүжилтийн оновчтой хувилбар боловсруулахад дэмжлэг үзүүлэхийг Монголбанкны ерөнхийлөгч Н.Золжаргалд зөвлөсүгэй.

3. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Уул уурхайн сайд Р.Жигжид нарт даалгасугай:

3.1. гол, мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээлт хийлгэх журам болон гэрээний загварыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, 2015 оны 4 дүгээр сарын 1-ний дотор Засгийн газрын хуралдаанд оруулж батлуулах;

3.2. усны сан бүхий газрын энгийн болон онцгой хамгаалалттай бүсийн хилийн заагийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шуурхай тогтоох;

3.3. ашигт малтмалын нөөцийн тодотгол, техник, эдийн засгийн үндэслэл болон байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланг бүртгэх, хүлээн авах ажлыг шуурхай зохион байгуулах;

111